



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/55

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг хэсэгчлэн
шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр баг, 14 дүгээр байрны хойд талд байршилтай, иргэн Лувсанцэнд овогтой Энхчимэгийн Үйлчилгээний зориулалттай 1200 м2 газрыг “Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ”-ний дагуу иргэн Асуд овогт Бат-Өлзийгийн Батчимэгт “Үйлчилгээ”-ний зориулалтаар, 600 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.


2. Өөрийн эзэмшилд үлдэж буй 600 м2 газрыг Үйлчилгээний зориулалтаар иргэн Лувсанцэнд овогтой Энхчимэгт 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

3. Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч иргэн Лувсанцэнд овогтой Энхчимэг, Бат-Өлзийгийн Батчимэг нарт үүрэг болгосугай.

4. Газар эзэмшигч иргэн Лувсанцэнд овогтой Энхчимэг, Бат-Өлзийгийн Батчимэгтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2017 оны А/97 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

421210398